



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/194.

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 26/23 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хот тохижилтын ажлын хүрээнд 2019 онд хийгдэх хөшөө дурсгалт зүйлсийг сэргээн засварлах, орчныг тохижуулахад шаардагдах хөрөнгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалын 1 дүгээр заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор байгуулсугай.

3. Сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР




Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 07 сарын 17 өдрийн
А/194 тушаалын хавсралт



ХОТ ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД 2019 ОНД ХИЙГДЭХ ХӨШӨӨ ДУРСГАЛТ
ЗҮЙЛСИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ, ОРЧНЫГ ТОХИЖУУЛАХАД ШААРДАГДАХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл арга хэмжээний нэр, байршил	Тоо хэмжээ м.кв	2019 онд санхүүжих /сая төгрөг/
1.	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Ум уулан дахь Чингис хааны сэрэг дүрийг сэргээн засварлах ажил	1	5.0
2.	Хан-Уул дүүрэг, 1 дүгээр хороо, "Торгоны зам" цогцолборыг сэргээн засварлах ажил	1	2.0
3.	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Цэрэндоржийн гудамжин дахь "Бүжин хооллож буй охин" баримал, Чингэлтэй дүүрэг, Хэлмэгдэгсдийн хөшөө орчмыг сэргээн засварлах ажил	1	3.5
	Дүн	3	10.5

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 07 сарын 02 өдрийн
А/194 тушаалын дүрмэвсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	Б.Отгонбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Д.Лувсанчимэд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Билгүүн	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10-р хорооны иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн